ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

# Өвөрхангай аймгийн Баянгол сумын ЕБС-ийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ӨВА-2023/127/НА-СТА-ТШ3**

Цахим хуудас: www.audit.mn

Өвөрхангай аймаг,
Арвайхээр сум

2023 он


Тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Гансүх

Утас: 70323833 Цахим хаяг: gansukh.audit@gmail.com

Ахлах аудитор: Б.Эрдэнэцэцэг

Утас: 70323108 Цахим хаяг: erdenetsetsegb@audit.gov.mn

Чадварлаг Аудит ХХК-ийн захирал: Д.Рэнцэнханд

Утас: 99200034 Цахим хаяг: chadvarlagAudit@gmail.com

Аудитор: П.Сосорбурам

Утас: 94422277 Цахим хаяг: psosor@yahoo.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Хараат бус аудиторын дүгнэлт....3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга....11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа....11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин....11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал....12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт....12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....13
4. Аудитын тайлан....15
4.1 Ерөнхий зүйл....15
4.2 Материаллаг байдал....15
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт....16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал....16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал....16
5. Аудитын илрүүлэлт....17
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл....18

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

## 1.Хараат бус аудиторын дүгнэлт

БАЯНГОЛ СУМЫН ЕБС-ИЙН
ЗАХИРАЛ Б.ЧАНЦАЛДУЛАМ ТАНАА

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2023. 02. 09 № 49
танай ____________-ны №____________-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянгол сумын ЕБС-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Баянгол сумын ЕБС-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон зүйл**

Цаашид зардлын эдийн засгийн ангиллын хүрээнд батлагдсан төсөвтөө захирагдан үйл ажиллагаа явуулах, ЗГ-ын 2022 оны "Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 448 дугаар тогтоолын биелэлтийг хангуулж, 2023 онд Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтэнд анхаарч ажиллах асуудлыг онцолж байна.

**Аудитын гол асуудлууд**

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Тус сургуульд Баянгол сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 33.9 сая төгрөг,улсын төсвөөс 26.9 сая төгрөгөөр хөрөнгө оруулалт хийгдсэн байна.Орон нутгийн өмчийн газрын шийдвэрээр 10.7 сая төгрөгийн хөрөнгө акталж,16.4 сая төгрөгийн хөрөнгө шилжүүлсэн байна.

**Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

015030300

D:\New Volume\2023 on\Bichig khereg\A4

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

D:\New Volume\2023 on\Bichig khereg\A4

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **107,200,223.93** | **111,420,691.18** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | - |
| **33** | **АВЛАГА** | 2,842,327.00 | - |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 2,842,327.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 104,357,896.93 | 111,420,691.18 |
| **351** | **Түүхий эд материал** | 12,782,969.79 | 12,782,969.79 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 12,782,969.79 | 12,782,969.79 |
| **354** | **Хангамжийн материал** | 90,167,427.14 | 92,949,081.39 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 931,700.00 | 2,051,800.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 5,309,810.00 | 4,450,510.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 634,679.00 | 625,769.00 |
| 35460 | Хүнсний материал | 4,801,360.00 | 4,304,320.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 78,489,878.14 | 81,516,682.39 |
| 35600 | Мал амьтад | 1,407,500.00 | 5,688,640.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,195,148,123.11** | **2,141,357,964.40** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **2,195,148,123.11** | **2,141,357,964.40** |
| **392** | **Биет хөрөнгө** | 2,120,348,123.11 | 2,066,457,964.40 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,194,249,716.85 | 2,201,711,866.66 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (227,326,501.20) | (295,077,226.96) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 98,141,549.01 | 138,141,549.01 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (19,490,562.28) | (44,383,331.92) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 88,169,514.30 | 92,729,514.30 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (43,179,991.96) | (57,700,588.28) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 15,000,000.00 | 15,000,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (6,750,000.00) | (7,500,000.00) |
| 39217 | Ном | 21,534,398.39 | 23,536,181.59 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 74,800,000.00 | 74,900,000.00 |
| 39301 | Програм хангамж | 490,000.00 | 1,390,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (490,000.00) | (490,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 74,800,000.00 | 74,000,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,302,348,347.04** | **2,252,778,655.58** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,302,348,347.04** | **2,252,778,655.58** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,302,348,347.04 | 2,252,778,655.58 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 677,529,387.01 | 677,529,387.01 |
| 51101 | Өмч: - төрийн | 677,529,387.01 | 677,529,387.01 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (172,650,188.78) | (220,821,630.01) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (147,349,225.22) | (171,251,938.55) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (25,300,963.56) | (49,569,691.46) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,797,469,148.81 | 1,796,070,898.58 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,302,348,347.04** | **2,252,778,655.58** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,051,838,754.59** | **1,232,153,033.20** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **67,528,242.59** | **58,489,033.20** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 67,528,242.59 | 58,489,033.20 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 67,528,242.59 | 58,489,033.20 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 1,933,500.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 62,684,351.91 | 50,481,783.20 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Материал | 4,843,890.68 | 6,073,750.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 984,310,512.00 | 1,173,664,000.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 815,979,800.00 | 962,691,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 962,691,600.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 815,979,800.00 | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 7,652,412.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,494,812.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,157,600.00 | - |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 160,678,300.00 | 210,972,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 160,678,300.00 | 210,972,400.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,073,299,718.15** | **1,267,840,849.39** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,073,299,718.15 | 1,267,840,849.39 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,049,533,198.15 | 1,218,893,129.39 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 663,341,300.00 | 759,106,202.00 |
| 210101 | Үндсэн цалин | 479,114,400.00 | 549,709,680.00 |
| 210102 | Нэмэгдэл | 147,811,500.00 | 167,904,711.00 |
| 210104 | Урамшуулал | 36,415,400.00 | 41,491,811.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 85,763,573.00 | 95,255,765.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 63,154,373.00 | 65,010,825.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,652,300.00 | 7,572,703.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,521,800.00 | 6,058,203.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,130,500.00 | 1,510,411.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,304,600.00 | 15,103,623.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 150,611,000.00 | 155,559,700.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,971,781.00 | 7,737,039.00 |
| 210302 | Түлш, халаалт | 144,733,819.00 | 146,852,661.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 905,400.00 | 970,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 5,754,350.00 | 27,643,865.75 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,419,600.00 | 8,456,820.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,822,020.00 | 4,772,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 465,300.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 239,400.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,808,030.00 | 8,499,900.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 5,914,245.75 |

| | | | |
|---|---|---|---|
| 2105 | Нормативт зардал | 28,783,310.00 | 40,275,740.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,525,530.00 | 64,600.00 |
| 210502 | Хоол, хүнс | 27,257,780.00 | 40,211,140.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,543,900.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 3,543,900.00 | - |
| 2107 | Томилолт, зочны зардал | 600,200.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 600,200.00 | - |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,133,500.00 | 6,328,700.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,557,500.00 | - |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 576,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 6,328,700.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 108,002,065.15 | 134,723,156.64 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 325,400.00 | 10,692,100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,481,882.00 | 570,990.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 102,194,783.15 | 121,260,066.64 |
| 210904 | Найдваргүй авлагын алдагдал | - | 2,200,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 23,766,520.00 | 48,947,720.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 23,766,520.00 | 38,975,760.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 22,646,520.00 | 38,975,760.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,120,000.00 | - |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | - | 9,971,960.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 9,971,960.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН | (21,460,963.56) | (35,687,816.19) |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 3,840,000.00 | 13,881,875.27 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 3,840,000.00 | 13,881,875.27 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН | (3,840,000.00) | (13,881,875.27) |
| 5 | НИЙТ ҮР ДҮН | (25,300,963.56) | (49,569,691.46) |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **984,310,512.00** | **1,175,597,500.00** |
| 11 | **ТАТВАРЫН ОРЛОГО** | - | - |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | - | **1,933,500.00** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | - | 1,933,500.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 984,310,512.00 | 1,173,664,000.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 815,979,800.00 | 962,691,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 962,691,600.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 815,979,800.00 | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 7,652,412.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,494,812.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 131105 | төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,157,600.00 | - |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 160,678,300.00 | 210,972,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 160,678,300.00 | 210,972,400.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 972,073,022.00 | 1,144,727,500.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 972,073,022.00 | 1,144,727,500.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 949,640,622.00 | 1,090,091,140.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 663,341,300.00 | 759,106,202.00 |
| 210101 | Үндсэн цалин | 479,114,400.00 | 549,709,680.00 |
| 210102 | Нэмэгдэл | 147,811,500.00 | 167,904,711.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | |
| 210104 | Урамшуулал | 36,415,400.00 | 41,491,811.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 86,405,900.00 | 94,613,438.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 63,796,700.00 | 64,368,498.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,652,300.00 | 7,572,703.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,521,800.00 | 6,058,203.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,130,500.00 | 1,510,411.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,304,600.00 | 15,103,623.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 143,915,600.00 | 155,559,700.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,971,781.00 | 7,737,039.00 |
| 210302 | Түлш, халаалт | 137,973,819.00 | 146,852,661.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 970,000.00 | 970,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 5,098,182.00 | - |
| 210401 | Бичиг хэрэг | 820,482.00 | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,700,000.00 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 465,300.00 | - |
| 210404 | Ном, хэвлэл | | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 364,100.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,748,300.00 | - |
| 2105 | Нормативт зардал | 33,179,430.00 | 39,714,100.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,716,530.00 | - |
| 210502 | Хоол, хүнс | 30,792,000.00 | 39,714,100.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 670,900.00 | - |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 6,371,010.00 | 2,425,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 6,371,010.00 | 2,425,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 600,200.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 600,200.00 | - |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,225,900.00 | 8,262,200.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,649,900.00 | 1,933,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 576,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 6,328,700.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,503,100.00 | 30,410,500.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 411,400.00 | 19,567,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,091,700.00 | 10,843,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 22,432,400.00 | 54,636,360.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 22,432,400.00 | 44,664,400.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 21,312,400.00 | 44,664,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,120,000.00 | - |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | - | 9,971,960.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 9,971,960.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 12,237,490.00 | 30,870,000.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН) | 12,237,490.00 | 30,870,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 12,237,490.00 | 30,870,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 12,237,490.00 | 30,870,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 12,237,490.00 | 30,870,000.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | (12,237,490.00) | (30,870,000.00) |

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| 2021 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл | 677,529,387.01 | 1,797,469,148.81 | (171,251,938.55) | 2,303,746,597.27 |
| 2021 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл | 677,529,387.01 | 1,797,469,148.81 | (171,251,938.55) | 2,303,746,597.27 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | (1,398,250.23) | - | (1,398,250.23) |
| Тайлант үеийн үр дүн | - | - | (49,569,691.46) | (49,569,691.46) |
| 2022оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 677,529,387.01 | 1,796,070,898.58 | (220,821,630.01) | 2,252,778,655.58 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 976,658,100.00 | 976,658,100.00 | 1,175,597,500.00 | 1,165,625,540.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 976,658,100.00 | 976,658,100.00 | 1,175,597,500.00 | 1,165,625,540.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 954,225,700.00 | 954,225,700.00 | 1,130,933,100.00 | 1,120,961,140.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 663,341,300.00 | 663,341,300.00 | 767,725,700.00 | 759,106,202.00 |
| 210101 | Үндсэн цалин | 479,114,400.00 | 479,114,400.00 | 589,320,500.00 | 549,709,680.00 |
| 210102 | Нэмэгдэл | 147,811,500.00 | 147,811,500.00 | 160,589,100.00 | 167,904,711.00 |
| 210104 | Урамшуулал | 36,415,400.00 | 36,415,400.00 | 17,816,100.00 | 41,491,811.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 86,405,900.00 | 86,405,900.00 | 95,965,900.00 | 94,613,438.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 63,870,400.00 | 63,796,700.00 | 65,256,900.00 | 64,368,498.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,633,900.00 | 5,652,300.00 | 7,677,200.00 | 7,572,703.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,507,100.00 | 4,521,800.00 | 6,141,800.00 | 6,058,203.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,126,800.00 | 1,130,500.00 | 1,535,500.00 | 1,510,411.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,267,700.00 | 11,304,600.00 | 15,354,500.00 | 15,103,623.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 143,915,600.00 | 143,915,600.00 | 155,559,700.00 | 155,559,700.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,223,700.00 | 4,971,781.00 | 6,666,300.00 | 7,737,039.00 |
| 210302 | Түлш, халаалт | 136,721,900.00 | 137,973,819.00 | 147,923,400.00 | 146,852,661.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 970,000.00 | 970,000.00 | 970,000.00 | 970,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 6,683,200.00 | 6,683,200.00 | | |
| 210401 | Бичиг хэрэг | 559,700.00 | 559,700.00 | | |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,700,000.00 | 1,700,000.00 | | |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 465,300.00 | 465,300.00 | | |
| 210404 | Ном, хэвлэл | 505,800.00 | 505,800.00 | | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 364,100.00 | 364,100.00 | | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,088,300.00 | 3,088,300.00 | | |
| 2105 | Нормативт зардал | 32,245,400.00 | 32,245,400.00 | 39,714,100.00 | 39,714,100.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 782,500.00 | 782,500.00 | | |
| 210502 | Хоол, хүнс | 30,792,000.00 | 30,792,000.00 | 39,714,100.00 | 39,714,100.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 670,900.00 | 670,900.00 | | |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 16,762,700.00 | 16,762,700.00 | 2,425,000.00 | 2,425,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 16,762,700.00 | 16,762,700.00 | 2,425,000.00 | 2,425,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 600,200.00 | 600,200.00 | - | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 600,200.00 | 600,200.00 | | |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,068,300.00 | 1,068,300.00 | 9,162,200.00 | 9,162,200.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 492,300.00 | 492,300.00 | 1,933,500.00 | 1,933,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 576,000.00 | 576,000.00 | | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | - | 7,228,700.00 | 7,228,700.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,203,100.00 | 3,203,100.00 | 60,380,500.00 | 60,380,500.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 411,400.00 | 411,400.00 | 49,537,500.00 | 49,537,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,791,700.00 | 2,791,700.00 | 10,843,000.00 | 10,843,000.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 22,432,400.00 | 22,432,400.00 | 44,664,400.00 | 44,664,400.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 22,432,400.00 | 22,432,400.00 | 44,664,400.00 | 44,664,400.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 21,312,400.00 | 21,312,400.00 | 44,664,400.00 | 44,664,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,120,000.00 | 1,120,000.00 | | |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 984,310,512.00 | 984,310,512.00 | 1,173,664,000.00 | 1,173,664,000.00 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 815,989,800.00 | 815,989,800.00 | 962,691,600.00 | 962,691,600.00 |
| 122005 | Орон нутгийн төсвөөс | 160,678,300.00 | 160,678,300.00 | 210,972,400.00 | 210,972,400.00 |

## 3. Санхүүгийн тайлангийн тодруулга

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянгол сумын Ерөнхий Боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

*Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар*

Бага дунд боловсролын тухай хуульд Ерөнхий боловсролын сургууль нь боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага юм гэж заасан.

Өвөрхангай аймгийн Баянгол сумын Ерөнхий Боловсролын сургууль нь 2022 оны хичээлийн жилд сургагчдын суурь мэдлэгийн чанарыг өндөр түвшинд хүргэх, ажлын чанар үр нөлөөг дээшлүүлэх, байгууллагын үйл ажиллагааг иргэдэд ил тод нээлттэй болгох зорилтыг дэвшүүлэн ажиллажээ. 2022 онд тавьсан зорилго:

Сургуулийн алсын хараа, эрхэм зорилгыг багш, ажилтан, эцэг эх, иргэдийн оролцоотой шинэчлэн тодорхойлох, хэрэгжилтийг ханган ажиллах

Эх хэлний чадамжаар тэргүүлэх сургууль байх бодлогоо үргэлжлүүлэн хэрэгжүүлэх

Олон улсын “Эко сургууль” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

*Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар*

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд доорх өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

Боловсрол Шинжлэх Ухааны Сайд болон Эрүүл Мэндийн Яамны Сайдын хамтарсан 2022 оны А/238, А/340 тоот тушаалаар батлагдсан “Багшийн эрүүл мэндийн талаар авах зарим арга хэмжээний талаар”,

Боловсрол Шинжлэх Ухааны сайдын 2022 оны А/259 дүгээр тушаал, Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн эрүүл мэндийн нэмэлт үзлэг оношилгоонд хамруулах заавар

Боловсрол Шинжлэх Ухааны сайдын 2022 оны 05 дугаар сарын 12-ний өдрийн А/170 дугаар тушаал, цэцэрлэг, сургуулийн цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар,

2022 оны 03 дугаар сарын 02-ний өдрийн 91 дүгээр тогтоол ,

Боловсрол Шинжлэх ухааны сайдын 2022 оны А/ 500 тоот тушаалаар батлагдсан сургалтын байгууллагын гүйцэтгэл үр дүнг үнэлэхэд баримтлах чиглэл гарсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Баянгол сумын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь аудитын байгууллагын үүрэг юм.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянгол сумын Ерөнхий Боловсролын Сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянгол сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна. 2022 онд нийт хөрөнгийн хэмжээ 49.6 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | 2842.33 | 00.0 | 00.0 |
| Бараа материал | 104,357.90 | 111,420.69 | 7,062.79 |

| | | | |
|---|---|---|---|
| Үндсэн хөрөнгө | 2,195,148.12 | 2,141,357.96 | ( 53,790.16) |
| **Нийт хөрөнгө** | **2,302,348.35** | **2,252,778.66** | **( 49,569.69)** |
| Өр төлбөр | 00.0 | 00.0 | 00.0 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | **2,302,348.35** | **2,252,778.66** | **( 49,569.69)** |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **2,302,348.35** | **2,252,778.66** | **( 49,569.69)** |

Дээрх хүснэгтээс харахад :Бараа материалын үнэ 7.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь оны эцэст дотуур байрны хүүхдийн хоол хүнсний материалын үлдэгдэл нэмэгдсэн байна Үндсэн хөрөнгийн дансны өөрчлөлт нь: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр дотуур байрны хайс, нойл 14.4 сая төгрөг, Биеийн тамирын талбай засвар 19.5 сая төгрөг нийт 33.9 сая төгрөгөөр хийгдсэн .Мөн нөхөн хангалтын зардлаар Технозон ХХК-аас 26.9 сая төгрөгөөр таблет , Ай ти зон ХХК-аас зөөврийн компьютер 3.0 сая төгрөгөөр нийт 29.9 сая төгрөгөөр ,Санхүүгийн программ 0.9 сая төгрөгөөр худалдан авсан. Эгшиглэн магнай ХХК-аас хандиваар 12 ш морин хуур 4.6 сая төгрөгөөр бэлэглэсэн.

БШУГазараас 1-р хоолны тогоо 1.6 сая төгрөг,махны машин 0.6 сая төгрөг химийн кабинетын шүүгээ 4.5 сая төгрөг,ном 2.0 сая төгрөг нийт 8.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар нэмэгдсэн.Чиглэл ХХК-аас 3.3 сая төгрөгийн 2-р хоолны тогоо үнэгүй өгсөн

Өвөрхангай аймгийн Орон Нутгийн Өмчийн газрын шийдвэрээр 0.7 сая төгрөгийн хашаа, 10.0 сая төгрөгийн биеийн тамирын талбай акталж данснаас хасаж 15.6 сая төгрөгийн сууцны барилга, 0.8 сая төгрөгийн газрын хамт сумын ЗДТГазарт шилжүүлсэн.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,135.3 сая төгрөг төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 962.7 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 210.9 сая төгрөгийн төсөв батлагдаж гүйцэтгэлээр улсын төсвөөс 962.7 сая төгрөгийг орон нутгийн төсвийн орлогоос 210.9 сая төгрөгийн санхүүжилт хийсэн байна. Орон нутгийн төсвийн санхүүжилтээс 9.9 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,144.7 сая төгрөг буюу 97.5 хувьтай зарцуулагдсан байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Цалин хөлс нэмэгдэл урамшуулал | 863,691.6 | 853,719.6 | 9,971.0 | 98.8 |
| 2 | Байр ашиглалтай холбоотой зардал | 155,559.7 | 155,559.7 | 0 | 100 |
| 3 | Нормативт зардал | 39,714.1 | 39,714.1 | 0 | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ | 9,653.7 | 9,653.7 | 0 | 100 |
| 5 | Урсгал шилжүүлэг | 44,664.4 | 44,664.4 | 0 | 100 |
| 6 | Бараа үйлчилгээний бусад зардал | 60,380.5 | 60,380.5 | 0 | 100 |
| 7 | Сурах бичгийн түрээс | 1,933.5 | 1,933.5 | 0 | 100 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

2022 оны Төсвийн гүйцэтгэлийн тайланд Бичиг хэрэг, Тээвэр шатахуун, Шуудан холбоо интернэтийн төлбөр, Ном хэвлэл, Хог хаягдал зайлуулах хортон мэрэгчдийн устгал ариутгал, Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс, Эм бэлдмэл эмнэлгийн хэрэгслийн зардлууд дээр санхүүжилт орж ирээгүйгээс Засгийн Газрын 91-р тогтоолын дагуу Бараа үйлчилгээний бусад зардал болон хичээл практикийн зардлаас гаргаж тайланд тусгасан байна.

Нийт 1,175.6 сая төгрөгийн санхүүжилтээс 1,165.6 сая төгрөгийг зарцуулж 9.9 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тус байгууллагын хувьд нэмэлт санхүүжилтээр авсан төсөв байхгүй.

### *3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

*Хөтөлбөр хэрэгжээгүй байна.*

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянгол сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Чадварлаг Аудит ХХК-ийн аудитор П.Сосорбурам гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Эрдэнэцэцэг, аудитын менежер Д.Гансүх, дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянгол сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 03 дугээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг 75 хувь гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын дүн 19.1 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 14.3 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагатай холбоотой 29 хуулийн шалгуур үзүүлэлтийг хамааралтай гэж үзэж үнэлсэн. Энэ хуулийн хүрээнд байр ашиглалтын зардлыг 1,070.7 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Уг хуулийн хүрээнд 1 төлбөрийн акт бичигдсэн.

Илрүүлэлт

Баянгол сумын Засаг даргын 2022 оны Б/24 тоот захирамжаар захирал Б.Чанцалдуламд гүйцэтгэлийн үнэлгээг болон ажлын үр дүнг харгалзан 1 сарын цалинтай тэнцэх шагналт цалин олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3."хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт

Цаашид төсвийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг хэрэгжүүлж төрийн хэмнэлтийн хуулийн дагуу арга хэмжээ авч ажиллан, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, биелэлтийг 2023 оны 04 дугаар сарын 01-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх төлбөрийн акт хүргүүллээ.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна. Тайлангийн хугацаанд нийцлийн аудит хийгдээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан гэж үзсэн.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг FAS программд оруулсан мэдээллийн дагуу тухайн байгууллагын шилэн дансны сайтаас мэдээллийг шалгасан.
*Шийдвэрлэсэн нь*:
Шилэн дансны хуулийн хэрэгжилт бүрэн хэрэгжсэн гэж үнэлсэн.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тухайн байгууллагын хувьд бусад нийцлийн асуудлын талаарх хамааралтай асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай *нийцсэн* гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын хувьд завсрын аудит хийгдээгүй байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | **0** | **0** | **0** | **0** | **0** |
| Албан шаардлага | 1 | 3870.0 | 1 | 3870.0 | 100 |
| Зөвлөмж | 1 | 0 | 1 | 0 | 0 |
| **Нийт дүн** | **1** | **3870.0** | **1** | **3870.0** | **100** |

Өмнөх аудитаар худалдан авалттай холбоотой 1 албан шаардлага өгч албан шаардлагын биелэлтийг хэрэгжүүлэн ажилласан байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулж, тухайн байгууллагын үндсэн үйл ажиллагааны зардлаас бусад зардалд төсвийн хөрөнгийг зарцуулахгүй байх.

Ур чадвар үр дүнгийн урамшуулал олгохдоо холбогдох журам зааврын дагуу олгож байх

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3.7 сая төгрөгийн 2 зөрчил илэрч 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт

Баянгол сумын Засаг даргын 2022 оны Б/24 тоот захирамжаар захирал Б.Чанцалдуламд 1 сарын цалинтай тэнцэх урамшуулал 0.9 сая төгрөг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3."хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт

Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаж, биелэлтийг 2023 оны 04 дугаар сарын 01-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх төлбөрийн акт хүргүүлж байна. Төлбөрийн актын биелэлтийг албан бичгээр нотлох баримтын хамт Төрийн аудитын газрын FAS системд оруулж илгээх

### 5.2 Албан шаардлага

Илрүүлэлт

Багш нарт олгосон ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтээр шалгаруулаагүй 2.7 сая төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон нь Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35, А/10,9 тушаалд Ур чадварын нэмэгдлийг албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэдэг, багшлахуй, суралцахуйн үйлийг бүтээлчээр хэрэгжүүлж онцгой амжилт гаргасан, шинийг санаачлан хэрэгжүүлж үр дүнд хүрсэн, туршлагаа бусдад түгээн дэлгэрүүлсэн багш, ажилтанд шалгуур үзүүлэлтийг баримтлан олгоно гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт

Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаж, биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 01-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх албан шаардлага хүргүүлж байна. Албан шаардлагын биелэлтийг албан бичгээр нотлох баримтын хамт Төрийн аудитын газрын FAS системд оруулж илгээх

### 5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөөгүй

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Дээрх төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Баянгол сумын Засаг даргын 2022 оны Б/24 тоот захирамжаар захирал Б.Чанцалдуламд гүйцэтгэлийн үнэлгээг болон ажлын үр дүнг харгалзан 1 сарын цалинтай тэнцэх шагналт цалин олгосон байна. | 1 | 964.8 | 1 | 964.8 | | | | | | | | |
| Багш нарт 2022 онд ур чадварын нэмэгдэл олгохдоо холбогдох тушаалын дагуу шалгуур үзүүлэлтээр ажил дүгнээгүй 2780.3 мянган төгрөгийн нэмэгдэл олгосон байна. | 1 | 2,780.3 | | | 1 | 2,780.3 | | | | | | |
| Дүн | 2 | 3,745.1 | 1 | 964.8 | 1 | 2,780.3 | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**
Нийцлийн аудитын асуудлаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад алдаа, зөрчил гараагүй.

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**